

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 08 дугаар сарын 11-ний өдөр  
Тендер шалгаруулалтын нэр: “**Дамжуулагч зэс утас**” нийлүүлэх  
Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202012303

**“Монголросцветмет” ТӨҮГ** эрх бүхий тендерт оролцогчдоос “Дамжуулагч зэс утас” нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100 хувиас багагүй байна.**

Тендерийн хамт 1,133,530 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 09:00 цагаас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 09:05 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрөхгүй.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 408 тоот өрөө, утас:  
450060 + 188

**“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ**